



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар A/30


Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дах хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, тайланг 2022оны 2 дугаар сарын 1-ний дотор Авлигатай тэмцэх газар хүргүүлэхийг Тамгын газар /Б.Батсүх/-т даалгасугай.
3. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоог хянаж, жил бүр төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.





Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2021 оны 03 дугаар сарын
01-ны өдрийн A/30 тоот тушаалтын
хавсралт

АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

/2021 ОН/

Нийгмийн даатгалын ерөнхий газар

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хариуцах нэгж	Хугацаа
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	АТГ-аас бэлтгэсэн Тв шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /facebook, youtube/, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	ТГ, СОНХАГ, МТТ	Жилийн турш
		Авлигатай тэмцэх газраас санаачилсэн аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулах зохион байгуулах	Дэмжиж, хамтран ажилласан байх Орон нутгийн хэлтсүүдэд зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	ТГ, Аймаг, нийслэл, дүүргийн НДХ-ҮҮД	Жилийн турш
		Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэл сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх	ТГ, МТТ	Жилийн турш

		самбар ажиллуулах	АТГ-аас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх		
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгтулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	ТГ	I улиралд
		АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Нийт газар, хэлтэс	Жилийн турш
		Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдүйн нөөц бололцоо, сургач багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайллагнасан байх	Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх Хамрагдсан хүүхэд, залуус, иргэдийн тоо	ТГ, СОНХАГ, Аймаг, дүүргийн НДХ-ҮУД	Жилийн турш
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ,	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайлбар хүргүүлсэн байх	Нийт газар, хэлтэс	Жилийн турш
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдсэн байдал	Аливаа санал санаачилгыг дэмжиж ажилласан байх	Нийт газар, хэлтэс	Жилийн турш
		Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх	Гэрээ хэлэлцээрт тодорхой заалт оруулсан байх	Нийт газар, хэлтэс	Жилийн турш
5	Авлига, ашиг сонирхлын	Авлигын эрсдэл ба авлига гарах	Шинэ шийдэл,	Нийт газар,	Жилийн



	зөрчил үүсгэх шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах	боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	технологи, нэвтрүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	хэлтэс	турш
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, олон нийт үзэж танилцах боломжоор хангах	Хуулийн хэрэгжилтийг ханггуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	Нийт газар, хэлтэс	Жилийн турш
7	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага боловсруулах	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гишүүдэд зориулсан ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах гарын авлага боловсруулан түгээх	Гарын авлагыг кэйс, тохиолдолд тулгуурлан боловсруулах	НДЕГ, АТГ	2021.04.01 2021.05.01

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

